

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	0
Хуралдааны товч тэмдэглэл:	1-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-16
1. “Ажлын хэсгийн удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл	4-5
2. “Ажлын хэсгийн удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл	5-6
3. “Зээлийн хүүг бууруулах стратеги батлах тухай” Улсын Их Хурлын 2020 оны 21 дүгээр тогтоолын хэрэгжилт, үр дүнтэй танилцаж санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлт	6-9
4. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны эзэмшлийн болон “Хөдөө аж ахуйн корпорац” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанид бүртгэлтэй хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдах бэлтгэл ажлын явц, хөрөнгийн үнэлгээний талаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын мэдээллийг сонсох	10-16

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны
06 дугаар сарын 25-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Р.Сэддорж ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 05 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Х.Баттулга, Г.Лувсанжамц;

Тасалсан: Ж.Алдаржавхлан, Э.Батшугар, Х.Ганхуяг, Ч.Лодойсамбуу, О.Цогтгэрэл.

Нэг. “Ажлын хэсгийн удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Р.Сэддорж танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Р.Сэддорж: “Ажлын хэсгийн удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 6

Бүгд: 15

60.0 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 11 цаг 09 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. “Ажлын хэсгийн удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Р.Сэддорж танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Р.Сэддорж: “Ажлын хэсгийн удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 6

Бүгд: 16

62.5 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 11 цаг 12 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.*“Зээлийн хүүг бууруулах стратеги батлах тухай” Улсын Их Хурлын 2020 оны 21 дүгээр тогтоолын хэрэгжилт, үр дүнтэй танилцаж санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлт*

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд танилцуулав.

Санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд хариулж, тайлбар хийв.

Р.Сэддорж: “Зээлийн хүүг бууруулах чиглэлээр авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 7

Бүгд: 18

61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Уг асуудлыг 11 цаг 23 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.*Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны эзэмшлийн болон “Хөдөө аж ахуйн корпорац” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанид бүртгэлтэй хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдах бэлтгэл ажлын явц, хөрөнгийн үнэлгээний талаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын мэдээллийг сонсох*

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэ, мөн хэлтсийн мэргэжилтэн Г.Нямдаваа, “Хөдөө аж ахуйн корпорац” ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Цогтсаран, мөн компанийн Ерөнхий нягтлан бодогч Б.Сосорбарам, хуулийн мэргэжилтэн С.Бат-Өлзий нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны эзэмшлийн болон “Хөдөө аж ахуйн корпорац” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанид бүртгэлтэй хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдах бэлтгэл ажлын явц, хөрөнгийн үнэлгээний талаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэ мэдээлэл хийв.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, М.Бадамсүрэн нарын тавьсан асуултад Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэ хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар, М.Бадамсүрэн, Р.Сэддорж нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны эзэмшлийн болон “Хөдөө аж ахуйн корпорац” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанид бүртгэлтэй хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдах бэлтгэл ажлын явц, хөрөнгийн үнэлгээний талаарх мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 11 цаг 50 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 45 минут үргэлжилж, ирвэл зохих 25 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 72.0 хувийн ирцтэйгээр 11 цаг 50 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Р.СЭДДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр, Лхагва гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим, 11 цаг 05 минут

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Р.Сэддорж: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Бадамсүрэн, Батболд, Батсүмбэрэл, Батчимэг, Бямбасүрэн, Ганбаатар, Жаргалан, Мандхай, Мөнхсоёл, Сайнзориг, Соронзонболд, Ундраа, Цэнгүүн, Энхтүвшин, Сэддорж нарын гишүүд хүрэлцэн ирсэн байна. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 60 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2025 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өчигдөр хуралдсан Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөлөөс хэлэлцэх асуудлын тов дарааллыг шинэчлэн баталсан байгаа.

Хэлэлцэх асуудал 1. “Ажлын хэсгийн удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл /Монголбанк дахь Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сангуудын зарцуулалт, үр дүнг хянан шалгах үүрэг бүхий ажлын хэсгийн удирдамж/

2. “Ажлын хэсгийн удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл /Ипотекийн зээлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хянан шалгах үүрэг бүхий ажлын хэсгийн удирдамж/

3. “Зээлийн хүүг бууруулах стратеги батлах тухай” Улсын Их Хурлын 2020 оны 21 дүгээр тогтоолын хэрэгжилт үр дүнтэй танилцаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлттэй танилцах

4 Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны эзэмшлийн болон “Хөдөө аж ахуйн корпорац” ТӨХХК-д бүртгэлтэй хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдах бэлтгэл ажлын явц, хөрөнгийн үнэлгээний талаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын мэдээллийг сонсох.

Ийм 4 асуудал байна. Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу. Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Хэлэлцэх асуудал 1.

“Ажлын хэсгийн удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Байнгын хорооны тогтоол

“Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай”

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.3, 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос тогтоох нь:

1.Монголбанкны 2024 оны санхүүгийн тайланг сонссонтой холбогдуулан Монголбанк дахь үндэсний баялгийн төрөлжсөн сангуудын хөрөнгийн зарцуулалт, үр дүнгийн талаар хяналт шалгалт хийж, санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол Улсын Их Хурлын шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий хяналт шалгалтын Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамжийг хавсралтаар баталсугай.

2.Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсэгт заасны дагуу бэлтгэж хэлэлцүүлэх, тогтоолын биелэлтийг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд 2025 оны намрын ээлжит чуулганы хугацаанд танилцуулахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

Байнгын хорооны дарга.

Ажлын хэсгийн удирдамж болон тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, санал хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье. Алга байна. Санал хураалт явуулж эхэлье. Гишүүд санал хураалтдаа бэлдье. Батсүмбэрэл гишүүн орсон байна уу.

“Ажлын хэсгийн удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 15-9 гишүүн дэмжиж, 60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

“Ажлын хэсгийн удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийн хэлэлцүүлэг дууслаа.

11.09 цаг.

Дараагийн асуудалдаа оръё. 2 дахь нь хэлэлцэх асуудал.

“Ажлын хэсгийн удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Байнгын хорооны тогтоол

“Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай”

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.3, 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос тогтоох нь:

1.Монголбанкны хэрэгжүүлж байгаа Орон сууцны ипотекийн зээлийн үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хянан шалгаж, санал, дүгнэлт гаргах

үүрэг бүхий хяналт шалгалтын ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамжийг хавсралтаар баталсугай.

2.Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсэгт заасны дагуу бэлтгэж хэлэлцүүлэхийг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд 2025 оны намрын ээлжит чуулганы хугацаанд танилцуулахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

Байнгын хорооны дарга.

Монголбанкнаас хэрэгжүүлж байгаа орон сууцын ипотекийн зээлийн үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хянан шалгах ажлын хэсгийн удирдамж болон тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, санал хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье. Алга байна. Санал хураалт явуулж эхэлье Гишүүд санал хураалтдаа бэлдье. Болчихсон.

“Ажлын хэсгийн удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 10 гишүүн дэмжиж, 62,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

“Ажлын хэсгийн удирд удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийн хэлэлцүүлэг явуулж дууслаа.

11.12 цаг.

Хэлэлцэх асуудал 3.

“Зээлийн хүүг бууруулах стратеги батлах тухай” Улсын Их Хурлын 2020 оны 21 дүгээр тогтоолын хэрэгжилт үр дүнтэй танилцаж, санал дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн санал дүгнэлттэй танилцаж эхэлье.

Ажлын хэсгийн ахлагч, Монгол Улсын Их Хурлын гишүүн Лхагвасүрэнгийн Соронзонболдыг ажлын хэсгийн санал, дүгнэлтээ танилцуулахыг урьж байна. Гишүүний микрофоныг нээе.

Л.Соронзонболд: Байнгын хорооны дарга, гишүүдийнхээ энэ өдрийн амрыг эрье.

Өмнөх Эдийн засгийн байнгын хорооны хурлаар зээлийн хүүг бууруулах стратегид тусгагдсан арга хэмжээг хянах ажлын хэсгээс явцын тайлангаа бол танилцуулсан байгаа. Гишүүдэд бол өнөөдөр ажлын хэсгийн товч тайланг хүргүүлсэн байгаа. Ингээд та бүхэнд санал, дүгнэлтээ танилцуулъя.

Зээлийн хүүг бууруулах стратегид тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлснээр зээлийн хүүг 2019 оны суурь түвшнээс 4 нэгж хувиар бууруулж, 2023 оны жилийн эцэст сарын 1 хувьд хүргэх зорилтыг тодорхойлсон бөгөөд 2023 оны эцсийн байдлаар арилжааны банкны зээлийн жигнэсэн дундаж хүү 17,25 хувь, Банк бус санхүүгийн байгууллагын зээлийн жигнэсэн дундаж хүү 39,6 хувьтай байна.

2024 оны эцсийн байдлаар арилжааны банкны зээлийн жигнэсэн дундаж хүү 16,6 хувь, Банк бус санхүүгийн байгууллагын зээлийн жигнэсэн дундаж хүү 42 хувь, мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгчийн зээлийн хүүгийн дээд хязгаар нь 54 хувьтай байна. Иймд стратегийн хэрэгжилт зорилтот түвшинд хүрээгүй гэж ажлын хэсэг дүгнэж байна.

Ажлын хэсэг хаврын чуулганы хуралдаанд ажиллах удирдамжтай байсан учраас ажлын хэсгийн үйл ажиллагааг дуусгаж, зээлийн хүүг бууруулах хүрээнд дараах арга хэмжээ авах нь зүйтэй гэж үзэж байна. Үүнд:

1 дүгээрт Монгол банк Санхүүгийн зохицуулах хорооноос дараах арга хэмжээг судалж, хэрэгжүүлэх арга хэмжээг авах шаардлагатай байна.

1.1.Эх үүсвэрийн өртгийг бууруулах зорилгоор банкны системийн тухайн хугацааны дундаж хүүгээс өндөр хүүтэй татсан хугацаатай хадгаламжийн заавал байлгах нөөцийн хэмжээг өсгөх, зохистой харьцааг тогтоох асуудлыг судлан шаардлагатай зохицуулалт хийх хэрэгтэй байна.

1.2.Банк болон Банк бус санхүүгийн байгууллагын гадаад зах зээлээс татсан валютын эх үүсвэрийг хугацаанаас нь хамаарч, үндэсний мөнгөн тэмдэгтэд хөрвүүлэх, зардлыг бууруулах.

1.3.Бизнесийн зээлд ашигласан эх үүсвэрт ногдох заавал байлгах нөөцийг бууруулж, ялгаатай тогтоох.

1.4.Арилжааны банкнууд эрсдэл багатай зээлдэгчид олгох зээлийн хүүгийн түвшнээ тогтоож, тогтмол хугацаанд нийтэд мэдээлдэг болох.

1.5.Монгол Улсад гадаадын банк үйл ажиллагаа эрхлэх харилцааг зохицуулсан эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох хүрээнд гадаадын банкны салбар байгуулах, үйл ажиллагаа эрхлэх нөхцөл шалгуурыг шинэчилж боловсронгуй болгох.

1.6.Банк болон банк бус санхүүгийн байгууллагууд хөрөнгийн зах зээлээр дамжуулан эх үүсвэр татахад дэд бүтцийн байгууллагатай холбогдох зардал, хугацааг бууруулах.

1.7.Банк бус санхүүгийн байгууллагын дүрмийн сангийн доод хэмжээг тогтоохтой холбоотой шаардлага, шалгуур нь эх үүсвэрийн зардлыг нэмэгдүүлж буй байдлыг судалж, төв болон орон нутгийн нөхцөл байдалд нийцүүлэн ялгамжтай тогтоох.

1.8.Зээлийн хүүгийн дээд хязгаарыг бизнесийн хэрэглээний болон бусад зээлийн эдийн бүтээгдэхүүн тус бүрээр төрөлжүүлэн судлах.

2.Хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай дараах асуудлуудыг ажлын хэсгийн гишүүд судалж, холбогдох хуулийн төслийг санаачлан өргөн мэдүүлэх.

2.1.Зээлийн эрсдэлийн зардлыг бууруулж, хэрэг маргааныг зардал багатайгаар шийдвэрлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Иргэний хууль, Иргэний

хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тухай хууль, Хөрөнгийн үнэлгээний тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах.

2.2.Харилцах болон хугацаагүй хадгаламжийн дансанд хүү, түүнтэй адилтгах төлбөр тооцохгүй байх, урт хугацаатай хадгаламжийн хүүгийн орлогын албан татвар бууруулах, гадаад валютын хадгаламжийг даатгалд хамруулахгүй байх зохицуулалтыг Банкн дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуульд тусгах.

2.3.Эх үүсвэр татах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор факторинг, профитинг зэрэг адилтгах хэлцлээр буюу шаардах эрхийн худалдаагаар олгосон санхүүжилтийг татвараас чөлөөлөх зохицуулалтыг Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд тусгах.

2.4.Зээлийн мэдээллийн сангийн хамрах хүрээг өргөжүүлж, зээлдэгчийн эрсдэлийг бодитой үнэлэх, Зээлийн чанарын үнэлгээг сайжруулах зорилгоор даатгал, үнэт цаас, худалдаа арилжааны гэрээ хэлцлийн үр дүнд үүссэн зээлтэй холбоотой авлага өглөг зэрэг бүх төрлийн мэдээллийг хамруулах зохицуулалтыг Зээлийн мэдээллийн сангийн тухай хуульд тусгах.

2.5.Санхүүгийн зах зээлийг дэмжих зорилгоор төрийн тусгай сангуудыг дотоодын хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулах боломжтой болгох, Зээлийн батлан даалтын сангийн өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх зохицуулалтыг холбогдох хуульд тусгах.

2.6 ЖДҮ-лэл эрхлэгчдийн зээлийн барьцааны шаардлагыг уян хатан болгох хүрээнд үл хөдлөх хөрөнгөөс гадна бусад хөрөнгө, гэрээний үүргийн биелэлттэй холбоотой мэдээллийг зээлийн мэдээллийн санд тусгах зохицуулалтыг холбогдох хуульд оруулах зэргийг болно.

Ингээд ажлын хэсгээс бол иймэрхүү ажлуудыг хийх шаардлагатай гэж үзэж байгаа. Үүнтэй холбоотойгоор тогтоолын төслийг бэлдсэн байгаа гэдгийг бас та бүхэнд тарааж танилцуулж байгаа. Тэгээд тогтоолын төслийг бол дараагийн Эдийн засгийн байнгын хорооны хурлаар батлуулах ийм саналтай байх болно.

Р.Сэддорж: Ажлын хэсгийн санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье. Алга байна. Ганбаатар гишүүнээр тасалж байна. Ганбаатар гишүүн.

Ж.Ганбаатар: Соронзонболд гишүүн сайн ажиллаж байх шиг байна. Тэгэхдээ 1 зүйл хэлэхэд дотор нь бас зүгээр банкныхны хүсээд байдаг ганц нэг юмнууд явж байна шүү. Тэрийг би бас тусгайлан уулзаад хэлье дээ. Микрофонд яриад яах вэ. Зээлийн хүүг одоо яг ингээд гадаа байгаа нөхцөл байдал чинь өөрөө иргэдэд ерөөсөө зээл олдохгүй байна л даа. Нөгөө банк бус байгууллагынхаа журмыг их чангатгачихсан юм байна лээ шүү дээ. Тэр хөрөнгийнхөө 50 хувиас дээшээ өгч болохгүй энэ тэр гээд. Одоо ингээд харж байхад бол банк бус санхүүгийн байгууллагууд чинь ломбард энэ тэр байгуулаад байгаа юм биш үү. Тэгээд хувь зээл гэдэг зүйл маш их хөгжчихсөн. Тэгэхээр бид нар яг энэ үед зээлийн хүүг нэлээн ийм байдалтай болгочихлоор яг бизнес эрхлэх гэж байгаа, дөнгөж өсөж

байгаа хүмүүст зээл бүр олдохгүй болчих болов уу гэж би энэ талаас нь харж байх юм.

Би ер нь 35 жилийн өмнө гэж бодоход би өөрөө ер нь банкнаас бол бараг зээл авч чаддаггүй байлаа шүү дээ. Яах вэ машин, байшингаа өгөөд зээл авдаг. Бусдыг нь бол би дандаа танил талаасаа мөнгө зээлдэг байсан. 35 жилийн өмнөхийг ярьж байгаа шүү. Өнөөдрийг биш.

Тэгэхээр наадах зээлийн хүүгийн стратеги гэдэг чинь яг цаг үеэ олсон болов уу, үгүй болов уу. Байнгын хорооны даргад бас хэлэхэд бол өнөөдөр ингээд ерөөсөө харж байхад бол банк зээл гаргахгүй. Яасан юм мэдэхгүй. Импортыг хязгаарлах, нөгөө валютын нөөцийг багасгана гээд иймэрхүү зүйлүүд чинь яг энэ цаг үед харин наадах чинь би бол яг зах зээлтэйгээ яаж уялдах бол доо гэж. Тэгээд зээл олдохгүй байгаа. Ер нь бол яах вэ, энэ жижиг дунд бизнес эрхлэгч нар чинь намайг юу гэдэг юм бэ дээ, энэ зовлонгоос хагас хугасыг нь ч гэсэн хуваалцчих болов уу гэж боддог юм уу над руу юмаа бичээд байдаг юм л даа. Тэгэхээр зээлийн хүүг хязгаарлана гээд нэлээн хатуу арга хэмжээ авчихаар яг бизнес эрхлэгч нарт зээл олдохгүй байх процесс чинь улам нэмэгдээд, сүүлийн үед ер нь банкуудыг харж байхад бол энэ яг зээлээсээ ашгаа олдог юм уу. Шал өөр зүйлээс л хөөцөлдөөд л явчихдаг юм шиг байгаа юм. Тэгээд банк бус санхүүгийн байгууллагаа чангалчихсан. Тэгэхээр хувь зээл гэдэг юм уу, шал өөр зүйл рүү иргэд чинь яваад, яг дөнгөж тулгуур байгаа хүмүүст чинь зээл олдохгүй байх нөхцөл байх вий. Би бусдыг нь бол дэмжиж байна шүү. Соронзонболд гишүүн ээ. Үг хэллээ.

Р.Сэддорж: Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Ажлын хэсгийн зүгээс Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6 дахь хэсэгт заасныг үндэслэн Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулсныг та бүхэнд тараасан байгаа.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8 дахь хэсэгт заасныг үндэслэн энэ төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхийг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулъя. Ажлын хэсгийн үр дүнд үндэслэн тогтоол гаргах нь зүйтэй гэсэн санал дэмжигдсэн тохиолдолд Ажлын хэсэг тогтоолын төслөө эцсийн байдлаар бэлтгэж, Байнгын хорооны дараагийн хуралдаанаар хэлэлцүүлнэ. Энэ хооронд ажлын хэсэг тогтоолын төсөл дээр гишүүдээс болон Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо зэрэг холбогдох байгууллагуудаас саналыг авч нэгтгээрэй.

Гишүүд санал хураалтдаа бэлдье.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8-д хэсэгт заасныг үндэслэн “Зээлийн хүүг бууруулах чиглэлээр авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 11 гишүүн дэмжиж, 61,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

“Зээлийн хүүг бууруулах стратеги батлах тухай” Улсын Их Хурлын 2020 оны 21 дүгээр тогтоолын төслийн тогтоолын хэрэгжилт үр дүнтэй танилцаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлттэй танилцаж дууслаа.

11.23 цаг.

Дараагийн асуудалдаа оръё. Хэлэлцэх асуудал 4.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны эзэмшлийн болон “Хөдөө аж ахуйн корпорац” ТӨХХК-д бүртгэлтэй хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдах бэлтгэл ажлын явц, хөрөнгийн үнэлгээний талаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын мэдээллийг хэлэлцэж эхэлье.

Төрийн өмчийн эд хөрөнгийг худалдах ажлыг зохион байгуулах ажлын хэсгийн ахлагч, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага зохицуулалтын хэлтсийн дарга Цэнддаваагийн Баяр-Эрдэнийг мэдээллээ танилцуулахыг урьж байна. Ажлын хэсгийн микрофоныг нээе.

Ц.Баяр-Эрдэнэ: Эрхэм гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе.

Засгийн газрын 2024 оны 152 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд зохион байгуулж буй ажлын талаар товч танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.4, 1.9-д төрийн байгууллагуудын эрхлэх асуудал, чиг үүрэг, үзүүлэх үйлчилгээ, үйл ажиллагааны хамрах хүрээг харгалзан нийслэл Улаанбаатар хотоос үе шаттайгаар нүүлгэн шилжүүлэх бодлогын хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн хөнгөн үйлдвэрийн яамыг холбогдох харьяа байгууллагуудын хамт Дархан-Уул аймагт нүүлгэн шилжүүлнэ гэж заасан.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 152 дугаар тогтоолоор Нийслэлийн Баянзүрх дүүргийн 23 дугаар хороонд байрлах Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны эзэмшлийн болон “Хөдөө аж ахуйн корпорац” ТӨХХК-д бүртгэлтэй, “Алтан Дорнод Монгол” ХХК-аас улсын төсвийн татварын өрөнд хураан авсан ашиглагдахгүй байгаа хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдах ажлыг 2024 онд багтаан шуурхай зохион байгуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт даалгасан.

Улмаар тус тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2025 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/01 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Тус ажлын хэсгийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага зохицуулалтын хэлтсийн дарга Баяр-Эрдэнэ миний бие ахлаад, Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, “Хөдөө аж ахуйн корпорац” зэрэг өмч эзэмшиж байгаа байгууллагуудаас төлөөллийг оруулаад ажлын хэсэг ажиллаж байгаа.

Тус ажлын хэсэг өнгөрсөн хугацаанд дуудлага худалдаагаар худалдах нийт хөрөнгөд хяналтын тооллого хийж, холбогдох хууль, тогтоомжийн дагуу дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүллээ.

1 дүгээрт “Хөдөө аж ахуйн корпорац” ТӨХХК-ийн эзэмшлийн газар дээр 2024 онд Азийн хөгжлийн банкны буцалтгүй тусламжийн санхүүжилтээр хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах МОН-

91, 92 төслийн хүрээнд баригдсан дэвшилтэт технологийн өвлийн шилэн хүлэмж нь “Хөдөө аж ахуйн корпорац” ТӨХХК-ийн үндсэн хөрөнгөд бүртгэгдээгүйг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанд танилцуулж, үндсэн хөрөнгөд нэмж бүртгэсэн байгаа.

Мөн Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 451 дүгээр тогтоолоор “Тариалан эрхлэлтийг дэмжих сан”, одоогийн “Хөдөө аж ахуйн корпорац”-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 777 сая 600 мянган төгрөгийн балансын үнэ бүхий лабораторийн зорилт бүхий барилгыг дагалдах тоног төхөөрөмжийн хамт Стандартчилал хэмжил зүйн газарт балансаас баланст шилжүүлэх зөвшөөрлийг олгож, тэр ажил нь өнөөг болтол хийгдээгүй байсныг 2024 оны 12 дугаар сарын 4-ний өдөр Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд албан бичиг хүргүүлж, Улаанбаатар хотын Хануул дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах контор, үйлчилгээний барилга зориулалттай 37870м² талбайтай газраас Стандартчилал хэмжил зүйн газарт 1638 метр талбайтай газрыг шилжүүлэн өгөхөөр материалыг бүрдүүлж ажилласан. Энэ үед бол энэ ДЦС ТӨХК-ийн эзэмшлийн газартай давхцаж байгааг бид бас залруулж, шинэчлэн кадастрын зургийг нь зуруулж, 36130м² болгон өөрчилж, эзэмшлийн газрын гэрчилгээг нь шинэчлэн авсан байгаа.

Мөн УБЕГ-аас 2024 оны 5/14775 дугаартай албан бичгээр дээрх эд хөрөнгүүд нь “Хөдөө аж ахуйн корпорац” ТӨХХК-ийн баланст бүртгэлтэй боловч “Алтан Дорнод Монгол” ХХК-ийн нэр дээр бүртгэлтэй, мөн уг үл хөдлөх хөрөнгийн захиран зарцуулах эрхийг нь Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны 2008 оны 0/81846 дугаартай албан бичиг, 2008 оны 1/36 дугаартай Хөрөнгийн эрх түдгэлзүүлэх тухай тогтоол, 2009 оны 1/4337, 02/6182, 2012 оны 2/6049, 2/10189 дугаартай албан бичгийг тус тус үндэслэн эрхийн улсын бүртгэлд тусгай тэмдэглэл хийсэн байсныг хийж хөрөнгийн захиран зарцуулах эрхийг түдгэлзүүлсэн байсныг Нийслэлийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт хандаж, тусгай тэмдэглэгээг арилгуулсан байгаа.

Бид өнгөрсөн хугацаанд дээрх зөрчил дутагдлуудыг арилгаж, ажлын хэсгийнхээ хүрээнд уг хөрөнгүүдийг дуудлага худалдаагаар зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж ажиллаж байна.

Энэ явцад Улсын Их Хурлын 52 дугаар тогтоол гарсан. Улсын Их Хурлын 52 дугаар тогтоолоор Улаанбаатараас орон нутагт шилжих, мөн тэр үед Улаанбаатарт үлдэж байгаа барилга байгууламж, объектуудыг холбогдох Байнгын хороонд танилцуулсны үндсэн дээр дуудлага худалдааг зохион байгуулахаар Засгийн газарт даалгасан Улсын Их Хурлын 52 дугаар тогтоолын хүрээнд өнөөдрийн танилцуулгыг хийж байна.

Р.Сэддорж: Ажлын хэсгийг танилцуулъя. Болорчулуун Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Баяр-Эрдэнэ Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага зохицуулалтын хэлтсийн дарга, Цогтсаран “Хөдөө аж ахуйн корпорац” ТӨК-ийн гүйцэтгэх захирал, Нямдаваа Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн, Бат-Өлзий “Хөдөө аж ахуйн корпорац” ТӨК-ийн хуулийн мэргэжилтэн, Сосорбарам “Хөдөө аж ахуйн корпорац” ТӨК-ийн Ерөнхий нягтлан бодогч.

Ажлын хэсгийн мэдээлэлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгье. Сайнзориг, Бадамсүрэн гишүүнээр тасалъя. Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг асуулт асууж, үг хэлнэ.

П.Сайнзориг: Нийслэлийн Баянзүрх дүүргийн 23 дугаар хороонд байрлах гээд энэ тогтоолын агуулга дээр явж байгаа. 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 152 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж орж ирж байгаа гэж байгаа. Зөв тээ. Энэ тогтоол маань хэрэгжээд дуусчихсан. Тэгэхээр би энийг Байнгын хорооны дарга анхааралдаа аваач ээ гэж хүсэж байгаа юм.

Өөрөөр хэлэх юм бол тодорхой объектуудыг байгаа, хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдаалах ажлыг 2024 онд багтаан зохион байгуулахыг даалгасан. 2024 онд багтаагүй. 2024 онд дуусчихсан. Өнөөдөр 2025 оны 6 дугаар сарын хэдний өдөр вэ. Тэгэхээр бид хэд энэ тогтоолыг хэлэлцээд, тодорхой ямар нэгэн чиглэл өгч болохгүй. Энэ үйл ажиллагааг тэр ондоо багтаа гэсэн, тэр оноосоо цаашаа бол дахиад Улсын Их Хуралтайгаа ярьдаг юм уу холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрээ оруулж ирэх ёстой. Тэгэхээр өнөөдөр ийм зүйлүүдийг бас ингээд бид нар бас энэ юмнуудынхаа үг, үсгийг эд нарыг сайн харж баймаар байна. Манай зөвлөхүүд бас сайн хэлээрэй. Бид хэд энэ дээрээ ингээд 2024 онд багтаан гэдэг Улсын Их Хурлаас өгсөн тогтоолыг ярих гэж байгаа шүү. Тэгээд багтааж чадаагүй юм байна. Одоо ямар чиглэл авч орох гэж байгаа юм бүү мэд. Тэгээд ажлаа хийж чадаагүй юм чинь энийгээ буцаад ямар байдлаар ... харин тийм Засгийн газрын тогтоол юм байна шүү дээ энэ чинь бүр үндэслэх гээд байгаа юм. Тэгэхээр энэ зүйлүүд байна. Тэгэхээр энэ асуудлуудаа бид нар бас Засгийн газрын тогтоолыг үндэслээд, энэ чинь яг ингэж орж ирэх нь зөв юм уу. Энэ чинь дуудлага худалдаагаар худалдаалах тодорхой объектуудын жагсаалтыг нэгдсэн байдлаар уг нь оруулж ирдэг шиг санах юм. Тэгээд ийм зүйлүүд байх юм. Тэгээд нэгэнт Засгийн газрынх нь тогтоолынх ч гэсэн үйлчлэх хүрээ хязгаарыг нь заагаад өгчихсөн. Дуусчихсан байгаа байхгүй юу. 2024 онд багтаан гэсэн байна шүү дээ Болорчулуун дарга аа. Та багтааж чадаагүй байна. Тэгээд одоо яах гэж ингэж оруулж ирсэн юм бол. Би ойлгохгүй байна. Тэгээд Засгийн газрын 2024 онд багтаан гэсэн тогтоолын үйлчлэх хүрээ, хугацаа дуусчхаад байхад бид хэд энийг нь үндэслээд өнөөдөр Улсын Их Хурал дээр энэ асуудлуудыг бас ярьж байгаа нь бас зөв үү: Би энэ дээр тодорхой хариулт авчихъя.

Р.Сэддорж: 2 номер хариулъя.

Ц.Баяр-Эрдэнэ: Сайнзориг гишүүний асуултад хариулъя. 2024 оны 10 сарын 30-ны өдрийн Засгийн газрын 152 дугаар тогтоол маш тодорхой заачихсан. 2024 онд багтаан шуурхай зохион байгуулахыг даалгасан. Бид 10 сарын 30-аас эхлээд энэ дуудлага худалдааг зохион байгуулах ажлыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлээд зохион байгуулаад явсан. Тухайлбал Засгийн газрын тогтоолд заасан хавсралт дээр байгаа Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны эзэмшлийн хөрөнгөтэй холбоо бүхий энэ барилга байгууламжийг нийтэд зарлаад, нээлттэй дуудлага худалдаа зохион байгуулаад процесс бол эхэлчихсэн явсан.

Улмаар Улсын Их Хурлын 52 дугаар тогтоол гараад 1 сарын 1-ээс хэрэгжиж эхэлсэн. Тэгээд Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт энэ Улсын Их Хурлын тогтоолын хүрээнд холбогдох танилцуулгыг хийж байж, дараагийн арга хэмжээг авна гэсэн агуулгатай албан

бичиг байсан учраас бид шуурхай зохион байгуулж байсан тэр ажлуудаа бол үндсэнд нь царцаасан гэж хэлж болохуйц ийм нөхцөл байдал үүссэн байгаа.

Р.Сэддорж: Засгийн газрын, Их Хурлын тогтоолыг бид нар бол хэрэгжүүлэх ийм агуулгаар бол хэлэлцэж байгаа. Тэгээд энэ Их хурлын тогтоолын 5 дугаар зүйл дээр нийслэл Улаанбаатар хотоос шилжин байрших боломжтой төрийн байгууллагуудыг орон нутаг дахь төрийн болон орон нутгийн өмчийн барилга байгууламжид байрлуулах, нийслэлд чөлөөлөгдөх барилга байгууламжийн тоо, байршил, зориулалтыг судлан жагсаалт гаргаж, Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд холбогдох Байнгын хороонд танилцуулж шийдвэр гарсны дараа тэднийг худалдах, худалдан авах ажиллагааг зохион байгуулна гэсэн энэ 5 дахь заалтын хүрээнд мэдээлэл сонсож байгаа.

Улсын Их Хурлын гишүүн Бадамсүрэн асуулт асууж,үг хэлнэ.

М.Бадамсүрэн: Ер нь төрийн өмчийг хувьчлахыг бол дэмжиж байгаа. Ер нь зөв л дөө. Тэгээд татварын өрөнд хураагдсан объект юм байна. Тэгээд энийг эргэлтэд оруулаад явах нь бол зөв. Гэхдээ хууль, эрх зүйн хувьд энэ бол асуудал дагуулах юм байна. Сая Сайнзориг гишүүний хэлсэн Засгийн газрын тогтоолыг бол дахин гаргах ийм шаардлагатай нөхцөл байдал үүсэж байна шүү дээ. 2024 ондоо Засгийн газрын тогтоол чинь гараад дуусчихсан. Улсын Их Хурлын тогтоолоор болохоор ерөнхий ийм заалт өгсөн. Жагсаалт гаргаж. Тэгэхдээ энэ чинь зөвхөн Дархан-Уул аймаг руу Хөдөө аж ахуйн яам шилжсэнтэй холбоотой гээгүй байна шүү дээ. Ер нь төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд, шилжин суурьшихын хүрээнд ямар жагсаалт орох юм бэ гээд. Тэгээд энэ чинь Улсын Их Хурлаар энэ төрийн өмчийн асуудлыг чинь хэлэлцдэг ийм хуультай шүү дээ. Яагаад гэхээр ард түмний төлөөллийн төв байгууллага буюу улсын түвшинд бол Улсын Их Хурал, орон нутагт бол орон нутгийн Хурлууд энэ өмчийн эзэн байдаг. Тэгээд энэ утгаар явж байгаа учраас энэ хууль, эрх зүйн хувьд асуудалтай л харагдаад байна даа. Тэгээд энэ нь болох юм уу. Байнгын хороо яг энэ асуудлыг нь авч хэлэлцээд, тэгээд энэ хуульдаа яг нийцэх үү. Тэгээд энэ дээр манай Их Хурлын Тамгын газрын Хуулийн газраас ямар дүгнэлт өгч байгаа юм бол. Тэгээд ингэж явахгүй бол нэг Байнгын хороогоор орж танилцуулсан нэртэй, тэгээд дараа нь ингээд асуудал гарчих вий. Хууль, эрх зүйн хувьд дараа нь хуулийн байгууллагад энэ асуудал чинь шалгагдах, тэгээд та бүхэн өөрсдөө албан тушаалтны хувьд асуудалд орох, Байнгын хорооны даргын хувьд энэ асуудал шаардлага хангасан уу, үгүй юу гэдэг дээр бас сайн бодож үзэхгүй бол хуульч гишүүн Сайнзориг гишүүн хэлж байна шүү дээ. Засгийн газрын тогтоолын үйлчлэл чинь дуусчихсан байна. Тэгээд 2024 ондоо чадаагүй байна. Ер нь яг үндэслэл нь бол эхлээд Засгийн газрын тогтоолыг та бүхний өгсөн энэ танилцуулга дээр Засгийн газрын тогтоолыг гаргаад өгчихсөн байна шүү дээ. Энэ Засгийн газрын тогтоол. Тэгээд энийг гол үндэслэж байгаа юм байна гээд. Тэгээд ийм ээдрээтэй юм гарчихсан байгаа учраас энийгээ яг хууль, эрх зүйн хувьд бол маш сайн тодорхой болгохгүй бол энд бас асуудал орох вий. Энэ дээр бас холбогдох Их Хурлын Байнгын хорооны хууль эрх зүй талаас нь Их Хурлын Тамгын газрын хууль, эрх зүй талаас н та бүхэн бас ингээд хариулт өгөөч ээ. Тэгээд энэ дээр итгэл үнэмшилтэй больё л гэж байгаа юм. Түүнээс биш төрийн өмчийг хувьчлахыг 100 хувь дэмжинэ. Хувьчлах нь зөв.

Р.Сэддорж: 2 номер.

Ц.Баяр-Эрдэнэ: Засгийн газрын тогтоол 10 сарын 30-нд гарсан. Тэгээд бид зохион байгуулалтыг хангахад дуудлага худалдаа зохион байгуулах журам, холбогдох хууль тогтоомжоор бол жишээ нь зарлахад 30 хоног, зохион байгуулалтын үнэлгээ хийлгэх гээд асуудлууд байгаа учраас тухайн ондоо бол цаг хугацааны хувьд багтахааргүй яг л ийм шахуу төлөвлөгөө байсан. Бид энэ зохион байгуулалтыг хангаад эхнээс нь үе шаттай явж байсан. Их Хурлын 52 дугаар тогтоол 12 сарын 12-нд гараад хэрэгжилт нь 1 сарын 1-ээс хэрэгжээд эхэлсэн учраас хууль, эрх зүйн хувьд ийм цаг хугацааны хайчинд бид үндсэндээ орсон. Тэгээд өнөөдөр бол байнгын хороонд танилцуулаад, дахиад Засгийн газарт тодорхой үүрэг даалгавар өгөгдөөд, тэгээд эхнээсээ бид Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд дахиад ажиллах ийм эрх зүйн хувьд ийм бололцоотой гэж харж байна.

Р.Сэддорж: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль энэ хуулийн 29 дүгээр зүйл дээр төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг хувьчлалаас гадуур худалдахад Засгийн газрын төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг төрийн өмчийн бодлого зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бусад эд хөрөнгийг тухайн хуулийн этгээдийн шийдвэрээр гагцхүү дуудлага худалдаагаар худалдаж болно гээд бүр тодорхой заачихсан байгаа. Тэгээд энэ бүрэн эрх нь Засгийн газарт байгаа. Тэгээд Их Хурал руу цаашдаа энэ хөрөнгө хувьчлах тухай асуудлыг оруулж ирэх нь бол зохимжгүй зүйл. Хувьчлах нь бол орж ирнэ. Худалдах нь бол орж ирэхгүй гэсэн үг. Хувьчлах нь бол орж ирнэ худалдах нь бол орж ирэх шаардлагагүй асуудлыг ингээд оруулж ирж байгаа. Тэгээд бид бол энэ Их Хурлын 52 дугаар тогтоолын дагуу л энэ мэдээллийг сонсож байгаа юм.

Ажлын хэсгийн гишүүдээс Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Хамт. Ажлын хэсгийн мэдээлэлтэй холбогдуулан үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгье. Бадамсүрэн гишүүнээр тасалъя. Ганбаатар гишүүний микрофоныг нээе.

Ж.Ганбаатар: Тийм ер нь сүүлийн үед Засгийн газар ер нь бүх зүйлээ Их Хурал руу хаядаг болчхоод л байгаа юм л даа. Бүх зүйлээс зугтаад л, хариуцлагаас зугтаад л. Хариуцлагаас зугтаж байна гэсэн үг шүү дээ. Тэгэхээр хариуцлагаас зугтаж байгаа юм бол хийгээд хэрэггүй л дээ. Би бас өчигдөр юун дээр Төсвийн байнгын хороон дээр сайд нарт 2, 3 үг хэлсэн юм. Тэгсэн ер нь сайд болоогүй учраас үг хэлээд байна гэж бодоод байх шиг байгаа юм. Зүгээр би бас микрофонд хэлье гэж бодож байгаа юм. Над руу бол санал тавьсан. Ерөнхий сайд, холбогдох хүмүүс. Тэгээд би өөрөө татгалзсан байгаа юм. Тэгэхгүй бол ер нь зүгээр сайд болоогүй учраас гоморхоод байна гэж боддог юм уу, яадаг юм. Тэгээд сайдаас бас татгалзаж болдог юм шүү дээ.

1 зүйлийг хэлэхэд энэ газрыг бол сонирхох хүмүүс их байх байх шүү. Хөдөө аж ахуйн яам энийгээ анхаараарай. Энэ үнээ тооцохдоо ер нь тэгээд нэлээн жоохон өндөрхөн шиг тавиарай гэж л үг хэлье дээ. Ер нь бол тэгээд шаардлагагүй байгаа объектуудыг бол хувьчлах нь зөв л дөө. Хувьчлах нь зөв. Тэгээд үнээ бол нэлээн өндөрхөн тавих хэрэгтэй. Тэгэхгүй бол ер нь зүгээр янз янзын байдлаас харж байхад бол 5 оролцогч гэдэг чинь 5-уулаа 1 талын оролцогч ороод ирдэг тохиолдол байдаг юм шүү дээ. 3 номерын дарга аа, зөвлөх өө. Тийм учраас наадхаа ер нь бол би зүгээр байршилгүй нь сая л харлаа л даа. Цастай зураг юм шиг байна. Ер нь бол мундаг байршилтай газар юм биш үү. Тийм учраас үнээ

нэлээн өндөрхөн шиг, дундаж үнэ гэж яриад хэрэггүй шүү дээ. Наадхаа жишиг болгоорой. Жишиг үнэ гэж байгаа шүү. Дундаж үнэ энэ тэр гэж яриад хэрэггүй байх. Энийгээ тэр засаг дээрээ сайн хэлээрэй дээ. Тэрийг бас сануулж хэлье. Надад бол ер нь өөрөө даахгүй байгаа зүйлүүдээ бол хувьчлаад явах нь бол зөв. Тэгэхгүй бол энэ байдлаараа бол бүр үнэгүйднэ. Бүр үнэгүй болно. Аягүй бол нөхдүүд очоод цемент цутгангуутаа шүүхдээд, танай газрыг булаагаад байна. Тийм байдаг юм байна лээ шүү дээ. Дотор нь жижигхэн нэг үйл ажиллагаа явуулж байна гэнэ үү, өр зээлдээ авч байна гэнэ үү тэгээд л энэ газрыг чинь аягүй бол хүмүүс тэгээд булаагаад авчихна шүү аягүй бол. Тийм учраас би бол дуудлага худалдаагаар өндөрхөн тавиад, нэлээн сайн оролцогч нар гаргаад, энэ журмаа сайн бариад эртнээс зарлаад, тэгээд орлогоо олох нь зөв байх гэсэн ийм бодол бол байна гэдгийг хэлье. Баярлалаа.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Бадамсүрэн.

М.Бадамсүрэн: Тэгэхээр ер нь Улсын Их Хурлаас баталсан хүчин төгөлдөр хуулийг 1 дүгээрт мөрдөх үү, Улсын Их Хурлын тогтоолыг эхлээд мөрдөх үү гэдэг асуудал дээр л энэ чинь орчхоод байна шүү дээ. Тэгэхээр хууль дээрээ бол төрийн өмчийн тухай хууль дээр Засгийн газар өөрөө шийдвэрээ гаргаж, хувьчлалаас бусад худалдах асуудлыг шийднэ гээд заачихсан байна шүү дээ. Тэгэхээр гарц нь бол Засгийн газар дахин өөрөө 2025 ондоо энийгээ зохион байгуулахаар тогтоол гаргах 1 дүгээрт.

2 дугаарт нь энэ Улсын Их Хурлын 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 52 дугаар тогтоолын хувьд бол 5 дугаар заалт нь төрийн байгууллагуудыг орон нутагт шилжихэд ямар барилга байгууламжид байрлуулах юм. Нийслэлд чөлөөлөгдөж байгаа барилга байгууламжийг тоо байршил, зориулалтыг судлан жагсаалт гаргаж ажиллах гэдэг ийм ерөнхий утгатай ийм заалт байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг та бүхэн хууль, эрх зүйн хүрээнд нь дахин сайн зөвлөгөө аваад, тэгээд хуулийнхаа дагуу зохион байгуулахгүй бол Улсын Их Хурлын зөвхөн энэ тогтоолын заалтыг бариад явбал дараа нь та бүхэн өөрсдөө асуудалд орох вий гэдэг л ийм болгоомжлол байна л даа. Болгоомжлол байна. Та бүхнийг бас эрсдэлээс хамгаалах нь хууль тогтоогчдын хувьд бол бас бидний үүрэг шүү дээ. Тэгээд та бүхэн энийг бас олон талаас нь ингээд бодоорой. Та бүхнийг бол ажил хийх гэж байгаа, юмаа шуурхай зохион байгуулах гэж байгааг бол ойлгож байгаа. Гэхдээ энэ хууль тогтоол Улсын Их Хурлаас баталсан Төрийн өмчийн төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль 1, 2-т нь Улсын Их Хурлын баталсан 2024 оны 52 дугаар тогтоол, 3-д нь Засгийн газрын 2024 онд баталсан энэ тогтоол 3 чинь хоорондоо уялдааг нь хангаж хуулиа 1 дүгээрт барих ийм шаардлага байна гэсэн үг.

2 дугаарт нь энэ ямар зүйл болдог вэ гэхээр бас миний бие 1 хуулийн төсөл санаачилгаар ажиллаж байгаа. Юу вэ гэхээр гадаад гэрээг Улсын Их Хуралтай зөвшилцөнө гэдэг ийм заалт байгаа юм. Тэгэхээр энийг зөвхөн Байнгын хороотой зөвшилцөөд, тэгээд Засгийн газар гэрээ явуулаад, дараа нь соёрхон батлуулахаар яваад байгаа байхгүй юу. Тэгээд энэ бас болж байна уу, үгүй юу. Сая Ж.Ганбаатар гишүүний хэлдгээр энэ бас ингээд Засгийн газар өөрөө бие дааж шийдэх боломжтой зүйлийг заавал Байнгын хороотой зөвшилцөх ямар хэрэг байна. Хариуцлагаа ер нь Засгийн газар өөрөө бүрэн хүлээгээд, нэгэнт хуулиар олгогдсон эрх нь байгаа тохиолдолд хариуцлагаа бүрэн үүрээд явах нь бол зөв харагдаад байгаа байхгүй юу. Тэгэхгүй бол ингээд зөвшилцсөн нэртэй, тэгээд ард нь

хариуцлага эзэнгүйдэх 2 дох ийм асуудал үүсэх вий гэдэг болгоомжлол байна. Тэгээд тийм учраас энийг бас Байнгын хорооны дарга, асуудал оруулж байгаа та бүхэн маань бас анхааралдаа авч сайн нягтлаасай л гэж бодож байна. Баярлалаа.

Р.Сэддорж: Гишүүд ажлын хэсгийн мэдээлэлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлж дууслаа.

Гишүүдийн хэлсэн саналуудыг сайн бичиж тэмдэглэж авч ажил хэрэгтээ чиглэл болгоорой. Засгийн газрын бүрэн эрхийн асуудал байгаа. Бүрэн Засгийн газар өөрөө шийдэх боломжтой. Ийм учраас өнөөдрийн хуралдаанаар тэмдэглэлээр чиглэл өгч байна. Байнгын хорооноос шийдвэр гаргахад бол бас зохимж тийм байна. Ийм учраас өнөөдрийн хуралдаанаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны эзэмшлийн болон “Хөдөө аж ахуйн корпорац” ТӨХХК-д бүртгэлтэй хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдах бэлтгэл ажлын явц, хөрөнгийн үнэлгээний талаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын мэдээлэлтэй танилцаж дууслаа.

Хуралдааны тэмдэглэлээр үүрэг чиглэл өглөө.

Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудал дуусаж, хуралдаан үүгээр өндөрлөж байна. Хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүд ажлын хэсгийнхэнд баярлалаа.

11.50 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ